



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 41 (178)

Монгол Улсын Хууль:

- *Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын тогтоол:

- *Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай*

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Зарим тэтгэлж, тусламжийн хэлжээг нэлэгдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арваннэгдүгээр сарын 7

№41 (178)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

433. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай (2000-10-26-ны хууль) 738

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

434. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт
оруулах тухай Дугаар 36 738
435. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох,
гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 37 738
436. Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний
тухай Дугаар 38 738
437. Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай
Дугаар 39 739

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

438. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 133 739
439. Төрийн өмчийн хорооны зохион байгуулалтын бүтцийг
шинэчлэн батлах тухай Дугаар 135 740
440. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх
барилга байгууламж, төсөл, арга хэмжээг шинэчлэн
батлах тухай Дугаар 136 740
441. Ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай Дугаар 137 746
442. Гүйцэтгэх захирлыг томилох тухай Дугаар 138 746
443. Агентлаг байгуулах тухай Дугаар 139 746
444. Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлөх,
томилох тухай Дугаар 140 748
445. Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай Дугаар 141 748
446. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 143 748
447. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай Дугаар 144 749
448. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн
батлах тухай Дугаар 145 749
449. Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай Дугаар 146 749
450. Зарим тэтгэмж, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх
тухай Дугаар 147 750
451. Согтуурах, мансуурах донтой өвчтөний талаар авах
зарим арга хэмжээний тухай Дугаар 148 750
452. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 149 750

Дөрөв. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

453. Журам батлах тухай /Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн
сайдын хамтарсан тушаал/ Дугаар 47,81 751



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч" гэснийг "Улсын дээд шүүхийн шүүгч"; 178 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчийн"

гэснийг "Улсын дээд шүүхийн шүүгчийн" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Гишүүн Н.Ганбямбыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их хурлын гишүүн Г.Төртөгтохыг Төрийн байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлж, Н.Ганбямбыг Аюулгүй байдал, гадаад бодлогын; Г.Төртөгтохыг Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Улсын Их Хурлын гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан Улсын Их Хурлын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 10 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйл, Шүүхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 1, 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Гишүүнээр томилсугай.
2.Банзрагчийн Дэлгэрмааг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

1.Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн "Байгаль орчны төлөв байдал"-ын 1999 оны тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Дор дурдсан арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:
1/газар хамгаалах, зохистой ашиглах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр газрын



багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлын 2000 оны намрын чуулганд хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх;

2/Байгаль орчны доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх, орчны бохирдлыг багасгах, байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулах, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах, иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр Байгаль орчны, Ашигт малтмалын, Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Байгаль орчны салбарын төв, орон нутгийн болон аж ахуйн нэгж, байгууллагын оновчтой бүтцийг бүрдүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, материаллаг баазыг бэхжүүлэх, бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох, байгаль орчны сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авах;

4/Нийслэл, томоохон суурин газрын орчны бохирдлыг багасгах, хог хаягдлыг цэвэрлэх, дахин ашиглах, заган ой, говийн бут сөөгийг хамгаалах зорилгоор шахмал, бусад төрлийн түлш, шаталт сайтай зуухаар хангах арга хэмжээг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр авч хэрэгжүүлэх;

5/Ой, бэлчээрийн хөнөөлт шавьж, мэргэчтэй

тэмцэх ажлыг байгаль орчинд халгүй аргаар зохион байгуулж, үр дүнг сайжруулах;

6/Усны хайгуул, судалгаа хийж, уст цэгийн тооллого явуулан бэлчээрийг усжуулах, усалгаатай газар тариаланг өргөжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх;

7/Бэлчээрийн даац чадавхийг тодорхойлох, тариалангийн талбайн бүртгэл, тооллого явуулах, бэлчээрийн талхагдлыг бууруулах, тариалангийн талбайн эзэмшилтийг сайжруулах ажлыг зохион байгуулах;

8/Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төв, орон нутагт байгалийн нөөцийг нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх;

9/Нийслэл, зарим аймагт газар, газрын хэвлий, ой, ан амьтны талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2001 оны эхний хагас жилд багтаан улсын үзлэг явуулж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Засгийн газрын бонд гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эдийн засгийн хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөлд эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, төсвийн цаг зуурын

хүндрэлийг давах, төсвийн алдагдлын тодорхой хэсгийг дотоодын эх үүсвэрээр санхүүжүүлэх зорилгоор Засгийн газраас 2000 он дуусталх хугацаанд 6 /зургаа/ тэрбум төгрөгийн бонд гаргахыг Засгийн газар /Н.Энхбаяр/-т зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын болон яамдын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын зөвлөх А.Баасанжав, Дэд бүтцийн хөгжлийн яамны Тамгын хэлтсийн дарга

Ш.Сономдагва, Хууль зүйн яамны ахлах мэргэжилтэн Д.Баярсайхан, Сангийн яамны мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Ц.Даваасүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлагын газрын дарга Д.Дэлгэрцогт нарыг Төрийн өмчийн хорооны орон тооны бус гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Төрийн өмчийн хорооны гишүүнээр Үйлдвэр, худалдааны яамны ахлах мэргэжилтэн А.Баасанжав, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Баярсайхан, Дэд бүтцийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ш.Сономдагва, Үндэсний татварын ерөнхий газрын Татвар хураалтын хэлтсийн дарга Я.Пүрэвэ нарыг тус тус томилсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өмчийн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 207 дугаар тогтоолын "Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын зөвлөх А.Баасанжав, Дэд бүтцийн хөгжлийн сайдын зөвлөх Ш.Сономдагва" гэснийг, "Гишүүнээс чөлөөлж, томилох тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 156 дугаар тогтоолын 1 дүгээр

зүйлийн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлагын газрын дарга Д.Дэлгэрцогт" гэснийг, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 113 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "Сангийн яамны мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Ц.Даваасүрэн, Хууль зүйн яамны ахлах мэргэжилтэн Д.Баярсайхан" гэснийг, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2000 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 53 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар
хот

**Төрийн өмчийн хорооны зохион
байгуулалтын бүтцийг шинэчлэн
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

1. Төрийн өмчийн хорооны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- өмч хувьчлалын газар:

- төрийн өмчийн төлөөлөл, удирдлагын

газар:

- төрийн өмчийн бүртгэл, хяналтын газар:

- тэмгэн газар

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн

өмчийн хорооны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн 139 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар
хот

**Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө
оруулалтаар хэрэгжүүлэх барилга
байгууламж, төсөл, арга хэмжээг
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2000 онд санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралтын, улсын төвлөрсөн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн барилга байгууламжийн жагсаалтыг 2 дугаар

хавсралтын ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, барилга байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, төслийн өч холбогдол, санхүүжилтийн байдалтай уялдуулан холбогдох яам, байгууллагуудтай тохиролцон, энэ тогтоолоор батлагдсан дүнд

багтаан хөрөнгийн зохицуулалт хийж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "2000 оны төвлөрсөн төсвийг биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2000 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 39 дүгээр тогтоолын

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР
Ч.УЛААН

Засгийн газрын 2000 оны 136 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төгрөг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	2000 оны төлөвлөгөө		Ерөнхий захиалагч
			Нийт төсөвт өртөг	Үүнээс: 2000 онд санхүүжүүлэх	
A	1	2	3	4	5
I. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР					
1. ДУЛААНЫ СТАНЦ					
1	Чойбалсан хотын дулааны цахилгаан станцын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө	1999-2000	1000.0	711.1	ДБЯ
2	Даланзадгад сумын дулааны цахилгаан станцын инженерийн гадна шугам сулгоо	1999-2000	1830.0	1830.0	ДБЯ
3	Дулааны гадна шугам, ф-1000 мм, 6.1 км /ТЭЦ-3-ТЭЦ-4-ийн хооронд/ Улаанбаатар	1999-2001	2000.0	100.0	ДБЯ
4	Дулааны төв шугамын шинэчлэлт, Сайншанд	2000	142.0	142.0	ДБЯ
5	Биокомбинатын гадна дулааны шугамын шинэчлэлт, Улаанбаатар	2000	345.5	345.5	ДБЯ
6	Дулаан, цэрвэр усны шугамын шинэчлэлт, Говьсүмбэр	2000	65.2	65.2	ДБЯ
7	Төвлөрсөн зуухны дуусгал, 2хКВТС-20, Зуунмод	1995-2000		11.7	ДБЯ
8	Сайншандын төвлөрсөн зуухны дутуу санхүүжилт	1999-2000		29.2	ДБЯ
	Дүн		5391.7	3243.7	
2. ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД ӨРТӨГ					
1	Сөгсай-Цэнгэл, 10 кВ, 1х04 мва, 37 км, Баян-өлгий	2000		110.2	ДБЯ
2	Мянгад-Эрдэнэбураг, 35 кВ, 1х04 мва, 58.2 км, Ховд	1999-2000	740.9	741.0	ДБЯ
3	Луус-Хулд, 35 кВ, 1х1 мва, 35 км, Дундговь	2000		525.9	ДБЯ
4	Баянхонгор-Шаргалжуут, 10 кВ, 1х04 мва, 32.3 км	2000	209.0	56.0	ДБЯ
5	Ханх-Монд, 10 кВ, 1х04 мва, 22 км	2000		9.1	ДБЯ
6	Луус-Эрдэнэдалай сум, 35кВ, 1х1мВа, 86км, Дундговь	1999-2000	1039.0	959.0	ДБЯ
7	Баянгол-Сайхан-овоо сум, 35кВ, 1х04мВа, 55км, Дундговь	1999-2000	688.0	515.4	ДБЯ
8	Баянгол-Сант сум, 10кВ, 1х04мВа, 50км, Өвөрхангай	1999-2000	250.0	166.2	ДБЯ
9	Бурэн-Дэлгэрхаан сум, 35кВ, 1х1мВа, 50км, Төв	1999-2000	776.0	565.0	ДБЯ
10	Баруун-урт-Халзан сум, 35 кВ, 1х04 мВа, 68 км, Сүхбаатар	2000	905.0	669.6	ДБЯ
11	Бэрх-Батноров сум, 35 кВ, 1х04 мВа, 35 км, Хэнтий	2000	572.0	459.3	ДБЯ
12	Өндөр-улаан-Тариат сум, 35 кВ, 1х04 мВа, 52 км, Архангай	2000	800.0	600.0	ДБЯ
13	Дэлгэрхаан-Баян-ендер сум, 10 кВ, 1х0.4 мВа, 40 км, Өвөрхангай	2000-2001	232.0	156.4	ДБЯ
14	Сэргээгдэх эрчим хүчний төсөл	2000-2001	800.0	200.0	ДБЯ
	Дүн		7011.9	5713.1	
3. УСАН ЦАХИЛГААН СТАНЦ					
1	Манханы УЦС-ын үерийн хамгаалалт, Ховд	1998-2000		15.0	ДБЯ
2	Богдын голын УЦС-ын сувгийн засвар, Завхан	1998-2000		52.0	ДБЯ
	Дүн			67.0	

A	1	2	3	4	5
II. НҮҮРСНИЙ САЛБАР					
1	Олонбулагийн нүүрсний уурхай, Ховд, Үенч сум	2000-2001	110.0	50.0	ДБЯ ЗДТГ
2	Баянтээгийн уурхайн ус шуруулах барилгын дутуу санхүүжилт	1999-2000		11.6	ДБЯ
Дүн			110.0	61.6	ДБЯ
III. ТЭЭВЭР					
1	Нисэх буудлын барилга, Баян-өгий	2000-2001	828.9	50.0	ДБЯ
Дүн			828.9	50.0	
IV. ХОТ БАЙГУУЛАЛТ					
1. АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ					
1	Цэвэрлэх байгууламж, 2100 м ³ /хонот, Мандалговь	1998-2000		30.0	ДБЯ
2	Цэвэр усны эх үүсвэрийн барилга, шугам, 2400 м ³ /хонот, Баянхонгор	1997-2000		60.0	ДБЯ
3	Марсын гудамжин: Энхтайвны өргөн чөлөө хуртлах цэвэр усны 0,7 км шугамыг 400 мм болгон өргөтгөх, Улаанбаатар	1998-2000		29.0	ДБЯ
4	Цэвэрлэх байгууламжийн дутуу санхүүжилт, Хөтөл	1999-2000		54.0	ДБЯ
5	Цэвэр усны шугам, 2700 м ³ /хонот, Өвөрхангай	1999-2000	175.0	100.0	ДБЯ
6	Цэвэрлэх байгууламжийн дуусгал, 1200 м ³ /хонот, Өндөрхаан	1993-2000	209.5	163.0	ДБЯ
7	Цэвэр усны системийн дуусгал, тохируулга, Цэцэрлэг хот	2000	70.0	70.0	ДБЯ
8	Хлоржуулах системийн шөвчлэлт, Архангай, Дорнод, Өмнөговь зэрэг	2000	50.0	72.6	ДБЯ
9	Бируун 5 аймгийн НААУ-г сэргээн хөгжүүлэх төслийн Монголын талын хөрөнгө (Зээл №1560)	1998-2001	714.0	305.0	ДБЯ
10	Сумдын халуун ус (10 сум, 3 аймгийн төвд)	2000	150.0	150.0	ЗДТГ
11	Цэвэр усны өндрийн савгийн дуусгал 6000 м ³ , Дархан-уул	1990-2000	459.6	250.0	ДБЯ
12	Хөдөөгийн сум суурин газрын ус хангамж, ариун цэврийг сайжруулах төсөл	2000	6.0	6.0	ДБЯ
13	Божир усны шугам, 3.1 км, Улаанбаатар	2000-2001	867.2	300.0	ДБЯ
Дүн			2791.3	1589.6	
2. ОРОН СУУЦ					
1	УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад байр худалдан авах	2000	318.0	342.0	УИХТГ
2	Улс төрийн талаар ойлг зэрэгт эзэмшсэн иргэд болон тэдний өр гэрийнхэнд байр худалдан авах	2000	200.0	200.0	ДБЯ ЗДТГ
Дүн			518.0	542.0	
V. ХӨДӨӨ АЖ АХУЙ					
1	Усаглаатай тариалын эрхлэх, Хөвдйн Булган, Үенч сум /500-5000 га/, гурилын үйлдвэр, Булган сум	2000-2001	190.0	90.0	ХХААЯ
Дүн			190.0	90.0	
VI. ЗРҮҮЛ МЭНД					
1	"Зрүүл мэндийн хөгжлийн хөтөлбөр"-ийн Монголын талын хөрөнгө	1998-2002	2644.0	645.6	ЭМЯ
2	Нэгдсэн эмнэлгийн В.Г. Блокжий аймаг дундын оношилгооны төв болгох, Өвөрхангай	2000	131.7	131.7	ЭМЯ
3	Жаргалант сумын эмнэлгийн барилгын дуусгал, Хөвсгөл	2000	10.0	10.0	ЭМЯ
Дүн			2785.7	787.3	

A	1	2	3	4	5
ҮН ГЭГЭЭРЭЛ					
1. БОЛОВСРОЛ					
1	Сургууль, 1176 суудал, Эрдэнэт	1998-2000		184.8	ЗДТГ
2	Сургуулийн дуусгал, 640 суудал, Уулбаян, Сүхбаатар	1999-2000		64.1	ЗДТГ
3	"Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн Монголын талын хөрөнгө	1999-2001		31.5	БСШУЯ
4	МСҮТ-ийн ерөгтөл, Увс	1999-2000	240.0	168.0	ЗДТГ
5	Сургуулийн барилга, 240 суудал, Цахир Архангай,	1999-2000	240.0	195.0	ЗДТГ
6	Жарсалант сумын 6 жилийн сургуулийн барилга, Архангай	1995-2001	205.0	75.0	ЗДТГ
7	Сургуулийн барилга 240 суудал, Цогт-овоо, Өмнөговь	1999-2000	200.0	210.0	ЗДТГ
8	Сургуулийн барилга, 13-р хороолол, 320 суудал, Улаанбаатар	1999-2000	350.0	283.0	ЗДТГ
9	Сургуулийн барилга, 320 суудал, Бөр-өндөр, Хэнтий.	2000-2001	400.0	110.0	БСШУЯ
10	Сургуулийн барилгын дуусгал, 928 суудал, Өндөрхаан, Хэнтий	1998-2001	700.0	134.0	БСШУЯ
11	Сургуулийн барилгын дуусгал, 320 суудал, Баянцагаан, Баянхонгор	1998-2001	51.0	51.0	ЗДТГ
12	8 жилийн 5-р сургуулийн "А" блокийн дуусгал, Өлгий сум, Баян-өлгий	1998-2001	200.0	100.0	БСШУЯ
13	Сургуулийн барилга, 240 суудал, Сүхбаатар сум, Сэлэнгэ	1998-2001	300.0	80.0	БСШУЯ
14	Сургуулийн барилга, 160 суудал, Эрдэнэ, Дорноговь	1998-2001	220.0	100.0	БСШУЯ
15	2-р 10 жилийн сургууль, Мөрөн, Хөвсгөл	2000	40.0	40.0	ЗДТГ
	Дүн		3146.0	1826.4	
2. СОЁЛ УРЛАГ, СПОРТ					
1	Аймгийн соёл, спортын төвийн барилгын дуусгал, Говь-алтай	1989-2000	238.0	197.0	ЗДТГ
2	Соёлын төвийн дуусгал, Алтай, Ховд	1998-2000	117.0	62.0	ЗДТГ
3	Соёлын төв, Хушаат, Сэлэнгэ	2000		15.0	ЗДТГ
4	Ж.Лхагвасүрэнгийн хөшөөний барилга	2000	31.8	31.8	БСШУЯ
	Дүн		386.8	306.8	
ҮН БАТЛАН ХАМГААЛАХ					
1	Бригадын цэргийн байр, Өвөрхангай	1999-2000	150.0	150.0	БХЯ
2	Тусгай салбарын байр, Үенн сум, Ховд	2000	48.0	48.0	БХЯ
3	Тусгай салбарын байр, Алтай сум, Говь-алтай	2000	72.0	72.0	БХЯ
4	Цэргийн байр, 200 хүн, Орхон	2000-2001	195.0	50.0	БХЯ
5	Орон сууц, 48 айл, Өвөрхангай	2000-2001	256.0	113.0	БХЯ
	Дүн		721.0	433.0	
IX. ГАДААД ХАРИЛЦАА					
1	Берлин дэх ЭСЯ-нд байр худалдан авах	2000	800.0	800.0	ГХЯ
	Дүн		800.0	800.0	
X. НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ					
1	"Гэнц худга"-ийн урьдчилан хорих төв	1999-2000	400.0	323.0	ЦЕГ
2	Цагдан хорих байрны ерөгтөл, Төв аймаг	2000	65.0	65.0	ЦЕГ
3	Цагдаагийн хэлтэс, цагдан хорих байр, Мандалговь сум, Дундговь	2000	100.0	100.0	ЦЕГ
4	Галын дөх, 5 мөшгөн гаравш, Бугдан аймаг	1999-2000	320.0	282.4	ГТТГ
5	Цагдаагийн барилга, Увс	2000-2001		15.0	ЦЕГ, ЗДТГ
	Дүн		885.0	785.4	

A	1	2	3	4	5
	ХI. ХИЛ ХАМГААЛАЛ				
1	Хойд хилийн дагуу тор татах	2000	197.0	197.0	ХЦУГ
2	Буга согоогийн зөстөв, Зөвхөн	2000	111.6	111.6	ХЦУГ
3	Нисэгийн зөстөв, цэргийн байр, уулзалтын байр, гал зуух, Зөвхөн	2000	85.2	85.2	ХЦУГ
4	Тамсаг булагт хилийн отряд байгуулах, Дорнод	1999-2001	735.0	185.3	ХЦУГ
5	Тэрэгтийн зөстөв, Сүхбаатар аймаг	2000	107.8	107.8	ХЦУГ
6	Арбулагийн зөстөв, Дорноговь	2000	94.1	94.1	ХЦУГ
7	Хилийн хорооны бохирын шугамын холболт, Сэлэнгэ	2000	24.0	24.0	ХЦУГ
8	Хилийн зөстөвүүдэн өрөмдөл худаг	2000	48.0	48.0	ХЦУГ
	Дүн		1402.7	853.9	
	ХII. ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ				
1	Хоригдлын ажлын байр бий болгох	2000	267.0	177.1	ХЗДХЯ
2	Цэргийн байр / Төв, Хөвсгөл аймаг/	2000	70.0	70.0	ХЗДХЯ
	Дүн		337.0	247.1	
	ХШ. БАЙГАЛЬ ОРЧИН				
1	Кадастрын судалгаа, газрын бүртгэлийн төслийн Монголын талын хөрөнгө	2000-2004		10.0	БОЯ
	Дүн			10.0	
	БАРИЛГА УГСРАЛТЫН НИЙТ ДҮН				
	ХҮ. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлын зардал		27216.0	17405.0	
	ХҮ. Тоног төхөөрөмж	2000	2370.4	2796.4	СЗЗЯ
	ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН				
	ХҮI. Их засвар		29586.4	29291.5	
	ХҮI. Их засвар	1999-2000	6115.5	2400.0	СЗЗЯ
	ХҮII. Замын сан Үүнээс:	1996-2003	35077.0	9982.1	ДБЯ
	Улсын замын сан			4383.5	
	Төвлөрсөн төсвийн санхүүжилт			5578.6	
	ХҮП. Гаалийн сан	1998-2000	4523.0	2000.0	УТЕГ
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН		75301.9	34653.6	

Засгийн газрын 2000 оны 136 дугаар
 тогтоолын 2 дугаар хэсгээр

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН БОЛОН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/ сая.төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хүчин чадал	Барих Хугацаа	Төсөвт өртөг	2000 оны зохируулсан төсөл	Үүнээс		Ашиглалтад оруулах	
						Замын сан	улсын төсөв	Хүч чадал	Улирал
А	1	2	3	4	5	6	7	8	9
Нэг. Хатуу хучилттай зам									
1	Балгануурын чиглэлийн зам	37.5 км	1999-2001	2626	150	60	90		
Хоёр. Төмөр бетон гүүр									
1	Архангайн Өлзийт, Орхон гол	171м	1996-2000	571.3	237	199.6	37.4	171м	IV
2	Хөвсгөлийн Галт, Идэрийн гол	162.9 м	2000-2001	280	20	20			
3	Сэлэнгэ Зүүнхараа, Хараа гол	170 м	1993-2000	588	158	60	98	170м	III
4	Завхань Евангэс, Төсвийн гол	144.9 м	1995-2001	440.1	190	190			
5	Булгань Тэшиг, Шийн гол	289.3 м	1994-2001	1137.2	400	340.3	59.7		
6	Увс Гашууны гол	72 м	1999-2000	269.4	269.4	230	39.4	72 м	IV
7	Архангайн Цэцхир, Тэрхийн гол	217.5м	1996-2000	436.5	110.5	60.5	50	217.5м	III
8	Хэнтийн Норовлын, Ула гол	77.8м	1996-2000	436.2	151	78.8	72.2	77.8м	III
1	Дорнод Эрэнцав, Ула гол	87.8 м	1999-2000	70	55	55		87.8м	III
Дөрөв. "Авто замын хууль" -ийн дагуу санхүүжүүлэх бусад арга хэмжээ, улсын зам засвар									
Тав. Гадаадын эзэлийн хөрөнгөөр хэрэгжих байгаа төслийн дотоод эх үүсвэр									
1	Кувейдийн сангийн эзэлээр хэрэгжиж байгаа Дархан-Эрдэнэтийн хатуу хучилттай замын Монголын талын хөрөнгө	184 км	1996-2001	6213.2	2575.7	872.8	1702.9		
2	АХБананы эзэлээр хэрэгжиж байгаа Улаанбаатар-Дархан-Аттанбулагийн замын өргөлтөд, шинэчлэлийн аялын Монголын талын хөрөнгө	312 км	1997-2000	6102	1796	629.5	1166.5	312 км	III
3	Дэлхийн банкны эзэлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хархорин-Цэндэргол-Тосонцэнгэлийн хэсэгчилсэн хайрган замын аялын Монголын талын хөрөнгө	80 км	1997-2000	1104.7	380			80 км	III
4	АХБананы эзэлээр хэрэгжих Налайх-Манит-Нойрын чиглэлийн замын аялын Монголын талын хөрөнгө	200 км	2000-2003	9000	106				
5	Дэлхийн банкны эзэлийн хөрөнгөөр хэрэгжих Эрдэнэсант-Арайсаар-Хөвд, Улаангом чиглэлийн замын аялын Монголын талын хөрөнгө	211 км	2000-2003	4070	303.7				
1999 оны санхүүгндээгүй үлдэгдэл									
ДУН									
	Зургаа, Орон нутгийн замын санд төвлөрүүлэх хөрөнгө		2000	2590.6	1659.8	587	1072.8		
	Үүнээс : Улаанбаатар хотод		2000	1100	9962.1	4383.5	5578.6		
			2000	1100	2590.6	2590.6			
					1100	1100			



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйл, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Жигмэдсүрэнгийн Батбаярыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Баагаагийн Баттөмөрийг Засгийн газрын

тохируулагч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын дэд даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Очирбатын Батбилэгийг Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Дуламсүрэнгийн Дорлигсүрэнг Монголын

хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар хот

Агент байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын дараахь тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудыг дор дурдсан сайдын эрхлэх ажлын хүрээнд байгуулсугай:

а/Ерөнхий сайд:

- Талнуулын ерөнхий газар;
- Төрийн өмчийн хороо;
- Радио, телевизийн хэрэг эрхлэх газар;
- Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлаг.

б/Засгийн газрын Хэрэг эрхлэх газар:

- Удирдлагын академи;
- Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх

газар.

в/Санхүү, эдийн засгийн сайд:

- Үндэсний татварын ерөнхий газар;
- Улсын гаалийн ерөнхий газар;
- Санхүүгийн улсын хяналт, шалгалтын

газар.

г/Гадаад хэргийн сайд:

- Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газар.

д/Хууль зүй, дотоод хэргийн сайд:

- Цагдаагийн ерөнхий газар;
- Хилийн цэргийг удирдах газар;
- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв;
- Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий

газар;

- Үндэсний архивын газар;

- Оюуны өмчийн газар;
- Гал түймэртэй тэмцэх газар;
- Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар.

е/Байгаль орчны сайд:

- Байгаль орчныг хамгаалах алба;
- Ус, цаг уур, орчны шинжилгээний газар;
- Газрын хэрэг эрхлэх газар;

ж/Батлан хамгаалахын сайд:

- Зэвсэгт хүчний ерөнхий штаб;
- Улсын иргэний хамгаалалтын газар.

з/Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны улсын хяналтын алба.

и/Дэд бүтцийн сайд:

- Дэд бүтцийн улсын хяналтын алба;
- Эрчим хүчний удирдах газар;
- Нүүрсний газар;
- Иргэний нисэхийн ерөнхий газар;
- Шуудан, цахилгаан холбооны газар;
- Аялал, жуулчлалын газар;
- Авто замын газар;
- Авто тээврийн газар;
- Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар;

- Төмөр замын хэрэг эрхлэх газар.

к/Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд:

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын улсын хяналтын алба;
- Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар;
- Хөдөлмөр зохицуулалтын газар;
- Улсын нийгмийн халамжийн газар.

л/Үйлдвэр, худалдааны сайд:

- Үйлдвэр, худалдааны улсын хяналтын алба;
- Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв;
- Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар;
- Газрын тосны хэрэг эрхлэх газар;
- Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын хурал.

м/Хүнс, хөдөө аж ахуйн сайд:

- Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба;
- Улсын нөөцийн газар;
- Улсын мал эмнэлгийн газар.

н/Эрүүл мэндийн сайд:

- Эрүүл мэндийн улсын хяналтын алба.

2.Дээр дурдсан агентлагуудын үйл ажиллагааны чиглэл, бүтэц, орон тоо, төсөв,

цалингийн санг холбогдох хууль тогтоомжийн дагуу баталж мөрдүүлэхийг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Алба байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 244 дүгээр тогтоол, "Ус, цаг уур, орчны шинжилгээний газар байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 253 дугаар тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 257 дугаар тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 297 дугаар тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 298 дугаар тогтоол, "Агентлагууд байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 300 дугаар тогтоол, "Дэд бүтцийн улсын хяналтын алба байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 301 дүгээр тогтоол, "Газрын тосны хэрэг эрхлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 303 дугаар тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 314 дүгээр тогтоол, "Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 12 дугаар тогтоол, "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 42 дугаар тогтоол, "Нийгмийн халамжийн удирдлага, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл, "Алба байгуулах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 71 дүгээр тогтоол, "Алба, газар байгуулах тухай" Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 132 дугаар тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн 172 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Аялал жуулчлалын үндэсний төв байгуулах тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 214 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН

ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ

ГАЗРЫН ДАРГА

Ө.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот

Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлөх, томилох тухай

Төрийн өмчийн хорооны бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэн болон ажлын шаардлагыг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн хорооны Тамгын газрын даргаар ажиллаж байсан Б.Шинэбаатар, Батлан хамгаалах яамны ахлах түшмэл Ц.Нямдорж, Хөрөнгийн биржийн захирлаар ажиллаж байсан О.Батбилэг нарыг Төрийн өмчийн хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Төрийн өмчийн хорооны гишүүнээр Төрийн өмчийн хорооны Тамгын газрын дарга Г.Цэндсугар, Ерөнхий сайдын нийгмийн бодлогын зөвлөх Ж.Хатанбаатар, Засгийн газрын ахлах референт Ц.Базар, Санхүү, эдийн засгийн дэд сайд Л.Энхтайван нарыг тус тус томилсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн өмчийн хорооны гишүүдийн бүрэлдэхүүнийг

батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 207 дугаар тогтоол, "Гишүүнээс чөлөөлж, томилох тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 156 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1999 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 113 дугаар тогтоол, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 189 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны гишүүнээр томилох тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 227 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 12-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Манжийн Дагвыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний агаарын тээврийг удирдах газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Манжийн Дагвыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Н.ЭНХБАЯР

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь: "Дайчилгааны тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 200 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Дайчилгаатай сургууль явуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн "нэг жилийн

өмнө" гэснийг "зургаагаас доошгүй сарын өмнө" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Н.ЭНХБАЯР

Ж.ГУРРАГЧАА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтанд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 266 дугаар тогтоолын хавсралтын "Б" хэсгийн 4 дэх заалтыг "Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга" гэж өөрчлөн найруулж, "Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай" Засгийн газрын 1999 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 84

дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад "18. Дэд сайд", "19. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга, дэд дарга", "20. Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН

САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтцийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12, 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

а/төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэс;

б/орон нутгийн байгууллагуудын хэлтэс;

в/мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс;

г/төрийн албаны боловсон хүчний хэлтэс;

д/хуулийн хэлтэс;

е/зохион байгуулалтын хэлтэс.

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоосугай.

3. Хэрэг эрхлэх газрын шинэ зохион байгуулалтын бүтцийн дагуу нэгжүүдийн чиг үүргийг шинэчлэн тогтоож, ажилтнуудыг зохистой

байршуулах арга хэмжээг батлагдсан орон тоо, төсвөө хэтрүүлэхгүйгээр хэрэгжүүлэхийг тус газрын дарга Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байгуулах тухай" Засгийн газрын 1993 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 88 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагын орон тоог дарга, тэргүүн дэд дарга, дэд дарга тус бүр нэг байхаар тогтоож," гэсэн хэсэг, "Зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 168 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ

ГАЗРЫН ДАРГА

Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18^д дугаар зүйл, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шарын Цогтоог Засгийн газрын тохируулагч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Жамьянгийн Батбаярыг Засгийн газрын

тохируулагч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын дэд даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН

САЙД

Ч.УЛААН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Зарим тэтгэмж, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн халамжийн сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмж, нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмж, ардын болон гавьяат цолтон, ахмад дайчдад болон дайнд амь үрэгдсэн дайчны эхнэр, нөхөрт олгох тусламж, Нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг тус тус 50 хувиар нэмэгдүүлж, энэ оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд энэ онд нэмж шаардагдах хөрөнгийг улсын төсвөөс гаргаж хугацаанд нь олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Ш.БАТБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Согтуурах, мансуурах донтой өвчтөний талаар авах зарим арга хэмжээний тухай

Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын харьяа Багахангай дүүрэг дэх Архинд донтох өвчтөнг албадан эмчлэх эмнэлгийг батлагдсан орон тоо, төсөв, хөрөнгийн хамт Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харьяалалд 2000 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөр тасалбар болгон шилжүүлж, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар болгон зохион байгуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт үүрэг болгосугай.

2. Согтуурах, мансуурах донтой өвчтөнг

албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын статус, үйлчилгээний хүрээг шинэчлэн тогтоох, өвчтөнд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг сайжруулах, хөдөлмөрлөх нөхцөл, ажлын байрвар хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

3. Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын зардлыг 2001 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 32 дугаар

тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Яамдын зохион байгуулалтын бүтцийг



батлах тухай" Засгийн газрын 2000 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "г/Байгаль орчны яам" гэсэн хэсгийн "Төрийн захиргааны удирдлага, мэдээллийн газар / Санхүү, аж ахуйн хэлтэстэй" гэснийг Төрийн захиргааны удирдлагын газар /Санхүү, аж ахуйн хэлтэстэй" гэж, "Байгаль орчны улсын хяналт,

үнэлгээний газар" гэснийг "Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар" гэж тус тус өөрчлөн найруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ

САЙД

Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

У.БАРСБОЛД

— САНГИЙН САЙД, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ —

2000 оны 03 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 47,81

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Авто замын тухай хуулийн 5 дугаар бүлгийн 18 дугаар зүйл, Засгийн газрын 1996 оны 149 дүгээр тогтоолыг үндэслэн **ТУШААХ** нь:

Нэг. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжигдэх авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэх, хянаж, санхүүжүүлэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Энэ журмыг 2000 оны 2 дугаар сарын 1-

нээс эхлэн мөрдөж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто замын газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН

САЙД

Г.БАТХҮҮ

Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/ 81 дүгээр хамтарсан тушаалын хавсралт

**ОРОН НУТГИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИГДЭХ
АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ,
ХЯНАЖ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр авто зам, замын байгууламжийн хайгуул зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, өргөтгөл их засвар болон урсгал засвар арчлалтын ажлыг гүйцэтгэх, хянаж санхүүжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах авто зам, замын байгууламжийн хайгуул зураг төсөл, засварын ажлын төсвийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, холбогдох байгууллага баталсан нөхцөлд хүчин төгөлдөр гэж үзнэ.

1.3. Хайгуул зураг төсөл, төсөв боловсруулах, зам гүүрийг барьж байгуулах, өргөтгөл их засвар болон урсгал засвар арчлалт хийх гүйцэтгэлийг сонгон шалгаруулахдаа төвлөрсөн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгаруулдаг нийтлэг журмыг баримтлан явуулна.

Хоёр. Орон нутгийн зам гүүрийн засварын ажлыг төлөвлөх

2.1. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр зам гүүрийг барьж байгуулах, өргөтгөл, их засвар, урсгал засвар арчлалт хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тухайн аймгийн Засаг даргын зохих албад урьд жилийн 8 дугаар сарын 1-ний дотор боловсруулж Сангийн яам, Авто замын газартай тохиролцоно.

2.2. Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр зам гүүрийг барьж байгуулах, өргөтгөл, их засвар, урсгал засвар арчлалт хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тухайн жилийн улсын хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусган Монгол Улсын Засгийн газар баталж байна.

Гурав. Хайгуул зураг төслийн ажлын хяналт, санхүүжилт

3.1. Хайгуул, зураг төсөл, төсвийн ажлын

даалгаврыг орон нутгийн засаг захиргааны мэргэжлийн албадаас боловсруулж тухайн аймаг, хотын Засаг дарга батална.

3.2. Зураг төсөл боловсруулах даалгаврын дагалдах материалд:

-тухайн төслийн талаарх дэлгэрэнгүй тайлбар;

-төслийг гүйцэтгэх аргачлал;

-ажлын явцад онцгойлон анхаарах зүйлс;

-зураг төслийн ажлын инженерийн үнэлгээ буюу өртөг зардлын тооцоо зэргийг хавсаргана;

-засварын ажилд шаардлагатай гэж үзвэл ажлын даалгавар гаргаж болно.

3.3. Хайгуул, зураг төсөл, төсвийн үнэлгээг мэргэжлийн байгууллага, хүмүүс тооцож тухайн аймаг, хотын Засаг даргаар батлуулна.

3.4. Хайгуул, зураг төсөл, төсөв боловсруулах гүйцэтгэгчийг сонгохдоо ажлын өртөг, хэмжээ цар хүрээндээ хамаарч шууд гэрээгээр болон сонгон шалгаруулалт хийх замаар сонгоно. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тохиолдолд:

а/ зургийн батлагдсан даалгавар;

б/ ажлын дэлгэрэнгүй тайлбар;

в/ үнийн санал /энэ нь нууц байна/ зэрэг материалуудыг боловсруулан нэгтгэж тендерийн комисст өгнө.

3.5. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай тендерийн комиссын мэдэгдлийг үндэслэн уг ажлыг гүйцэтгэх аж ахуйн гэрээг шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулж тухайн аймаг, хотын Засаг даргаар батлуулна.

3.6. Гэрээнд дараах материалыг хавсаргана. Үүнд:

-ажлын даалгавар;

-ажил гүйцэтгэх график;

-санхүүжилтийн график;

-ажилд тавих үндсэн нөхцөл, техникийн шаардлага.

3.7. Ажлын явцад дараах асуудлуудыг онцгойлон анхаарна. Үүнд:

-хайгуулын журналын хөтлөлт, түүний үнэн зөв эсэх;

-тооцооны аргачлал зөв эсэх;

-зураг төсвийн боловсруулалтын байдал;

-геологийн судалгааны дүгнэлт ажлын явц г.м

3.8. Гэрээний нөхцөл, ажлын явцыг үндэслэн шаардлагатай гэж үзвэл Засаг

даргын шийдвэрээр урьдчилгаа санхүүжилт олгож болно.

3.9. Бэлэн болсон зураг төсвийг гурван долоо хоногт багтаан мэргэжлийн байгууллага, хүмүүсээр экспертиз хийлгэн дүгнэлт гаргуулж аймаг, хотын Засаг дарга баталж хүчин төгөлдөр болгоно. Экспертиз хийх шаардлагагүй гэж үзвэл хяналтын инженер нэг долоо хоногт багтаан өөрөө шалгаж тухайн аймаг, хотын Засаг даргаар батлуулна.

3.10. Хайгуул, зураг төслийн материалыг дараах байдлаар хүлээн авна.

а/ хайгуул, зураг төсөл:

-геологи, гидрогеологи, бусад

хайгуулын анхан шатны эх материалууд;

-хайгуулын журналууд, тайлан;

-барилгын зургийн эх калькан материал;

-ажлын зургийг гэрээний дагуу хэвлэж олшруулсан материал;

-төсөв болон ажлын тоо хэмжээ;

-барилгын тэнхлэгийн улаан

шугам /актаар газар дээр нь үзэж/

б/ хайгуул судалгааны материал:

-төсөлтэй холбогдох фото зураг,

видео бичлэг;

-ажлын тайлан материалыг гэрээний дагуу хэвлэн олшруулсан материалууд зэрэг болно.

3.11. Баталгаажуулсан зураг төсвийг дараагийн шатанд ашиглахаар зохих албад, байгууллагуудад актаар хүлээлгэн өгөх бөгөөд эх материалуудыг архивт хадгална.

3.12. Тухайн зураг төсөв, төсөл арга хэмжээ нь ажлын шаардлага хангах боломжгүй гэж үзвэл санхүүжүүлэхээс татгалзана.

Харин ажлын шаардлага хангах боловч хагас дутуу, өнгө үзэмж, боловсруулалт хангалтгүй байвал гэрээгээр тохирсон үнийг 30% хүртэл бууруулан санхүүжүүлж болох ба энэ тухайгаа гэрээ дүгнэсэн актад тодорхой дурдсан байна.

3.13. Зам гүүрийн гадаслагаг тухайн орон нутгийн авто замын захиалагчийн хяналтын инженер ба гүйцэтгэгчийн төлөөлөгчид хүлээлгэж өгнө. Хүлээж авахдаа өнцгийн орой, репер, пикет бүрийн гадаслагаг гэрээ, техникийн нөхцлийн дагуу бэхэлсэн эсэхийг шалгаж схем гарган гарын үсэг зурж хүлээлцэнэ. Мөн геологийн судалгааны



цооногуудыг хамт хүлээлцэнэ.

3.14. Гольдролоо өөрчилдөг гол болон хөрс геологийн төвөгтэй нөхцөлд гүүрийн байршлыг тогтоохдоо аймаг, хотын Засаг даргын шийдвэрээр мэргэжлийн экспертизийн хэсэг томилж газар дээр нь эцэслэн шийднэ. Ингэхдээ шаардлагатай гэж үзвэл Авто замын газраас мэргэжлийн зөвлөлгөө авч болно.

3.15. Зам гүүрийн барилгын явцад батлагдсан зураг төсвийг өөрчлөх шаардлага гарвал авто замын улсын байцаагчийн санал дүгнэлтийг үндэслэн аймаг, хотын Засаг дарга шийдвэрлэнэ.

3.16. Хайгуул, зураг төслийн ажлын тайлан, бусад материалыг бүрэн хүлээж авсан тухай орон нутгийн авто замын захиалагчийн хяналтын инженерийн үйлдсэн актыг үндэслэн Засаг даргын шийдвэрээр санхүүжилт хийнэ.

Дөрөв. Зам гүүрийн барилга угсралт, засвар өрчлөлтийн ажлын хяналт, санхүүжилт

4.1. Тухайн зам гүүрийн зураг төсөл, хайгуулын ажил болон барьж байгуулах, засах, шинэчлэх гүйцэтгэчийг зохих журмын дагуу сонгосон мэдэгдэл гарсны дараа уг ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулах нөхцөл бүрдэнэ.

4.2. Дээрх шийдвэрийг үндэслэн авто замын захиалагчийн хяналтын инженер гүйцэтгэгч байгууллагатай аж ахуйн гэрээ байгуулж аймаг, хотын Засаг даргаар батлуулна.

4.3. Аж ахуйн гэрээнд дараах зүйлсийг хавсаргасан байна. Үүнд:

а/ тухайн ажлын урьдчилгаа болон санхүүжилтийн график;

б/ ажлыг явуулах график, тухайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ, тооцоо;

в/ ажилд тавих үндсэн нөхцөл, стандарт, техникийн шаардлага.

4.4. Шинээр эхэлж байгаа барилгын улаан шугамыг ажил эхлэхийн өмнө гүйцэтгэгчид хүлээлгэн өгч акт үйлдэнэ.

4.5. Авто замын захиалагчийн хяналтын инженер нь батлагдсан графикийн дагуу болон цаг үеийн ажлын шаардлагаар үе шатны ажил бүрд техникийн хяналтыг хийж, гүйцэтгэгчтэй хамтран дараах байдлаар ажил

бүр дээр тайлан дүгнэлтийг гаргана. Үүнд:

а/ засмал замд

-зам, гүүр, хиймэл байгууламжийн тэнхлэгийн гадаслагаа хийж өнцгийн орой, репер пикетүүдийг бэхэлсэн байдал / бэхэлгээний схемийг хавсаргах/;

- замын зурвас газрыг цэвэрлэж чөлөөлсөн тухай;

-замын зурвасын болон материалын орд газруудын ургамлын үе бүхий хөрсийг авч зайлуулсан байдал /далд ажлын акт, фото зураг хавсаргах/;

-замын даланг усалж үечлэн дагтаршуулсан байдал /далд ажлын акт, фото зураг, 1000 м тутамд нягтралыг шалгаж тодорхойлсон лабораторийн дүгнэлтийг хавсаргана/;

-замын далангийн өндрийг зургийн түвшинд нь хийсэн байдал /дагуу огтлолын гүйцэтгэлийн зураг, далд ажлын акт, фото зургийг хавсаргана/;

-замын хашлагыг тавьсан байдал / бетон дэрний далд ажлын акт, фото зураг/;

-бүх төрлийн бэхжүүлсэн хөрсөн болон хайрган, буталмал чулуун суурь хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг, 200 м тутамд хөндлөн огтлолын гүйцэтгэлийн зураг, суурийн зузаан болон нягтралыг 500 м тутамд шалгасан лабораторийн дүгнэлт/;

-хучилт хийхийн өмнө сууринд битумээр түрхлэг үе хийсэн байдал / далд ажлын акт, фото зураг/;

-хучилт хийсэн байдал /замын дагуу огтлолын гүйцэтгэлийн зураг, 500 м тутамд хөндлөн огтлолын гүйцэтгэлийн зураг, 200 м тутамд хучилтын зузаан, нягтралыг шалгасан лабораторийн дүгнэлт, хучилт хийсэн үеийн цаг уурын мэдээ, хучилтын материалын лабораторийн шинжилгээ/;

- замын далангийн налуу, хөвөө, бэлтгэл газрын тэгшилгээг хийж ургамалжуулсан байдал /фото зураг/;

-түмбэ, тэмдэг тавьсан байдал /фото зураг/;

-ашиглаж дууссан орд газрыг унаган төрхөд нь оруулсан байдал /фото зураг/;

-замын өөрийн болон уулын шуудууг байгуулсан байдал /дэвсгэр зураг болон дагуу огтлолын гүйцэтгэлийн зураг, фото зураг/.

б/ хиймэл байгууламж, ус зайлуулах хоолойд

-суурийн нүхийг ухаж хөрсийг зайлуулсан байдал /далд ажлын акт, фото зураг/;

-бетон, төмөр бетон хайрга, буталмал чулуун суурь хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг, суурийн зузаан, бетоны маркийг нягтралыг шалгасан лабораторийн дүгнэлт/;

-ус зайлуулах хоолойн цагирагуудыг угсарсан байдал /фото зураг, төмөр бетон эдлэлийн хийц хэсгийн хэмжээг тодорхойлсон гүйцэтгэлийн зураг, бат бэхийг тодорхойлсон лабораторийн дүгнэлт/;

-ус орох, гарах амсрын бэхэлгээ, гольдрол засалт /фото зураг/;

-цагирагуудын хоорондох чигжээс, ус тусгаарлалтыг хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг/.

в/ төмөр бетон гүүрт

-гүүрийн тэнхлэг, репер, тулгууруудын байршлын гадаслагаа, тэд- гэрийг бэхэлсэн байдал /бэхэлгээний схемийг хавсаргах/;

-гүүрийн хийц хэсгүүдийг бэлтгэсэн байдал /тэдгээрийн арматурын хийц хэсгүүдийг бэлтгэсэн болон угсармал эдлэл бүрийн марк, бат бэхийг тодорхойлсон лабораторийн дүгнэлт, фото зураг хавсаргах/;

-цемент, арматур, ус хайрга, чулуун материалуудын марк, чанар /материалын хими-физик-механикийн үзүүлэлтүүд, орцын норм тогтоосон лабораторийн дүгнэлт/;

-буугч худга, шон, угсармал болон цутгамал суурь хийсэн байдал /зургийн түвшинд суулгасныг баталгаажуулсан далд ажлын акт, фото зураг, геометрийн хэмжилтүүдийн үр дүн, цаг уурын товч мэдээ/;

-тулах хэсэг /опорная часть/ тавьсан байдал /фото зураг, хэмжилтүүдийн дүн, бэлтгэсэн материалын тухай мэдээ/;

-дам нуруу хоорондын агшилт тэлэлтийн компенсатор хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг/;

-арматур тавьж тэгшилгээний үе болон өнгө бетон хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг, бетоны марк тогтоосон лабораторийн дүгнэлт/;

-явган хүний замын хавтан, дугуй цохигчийг угсарсан байдал /фото зураг, бетон эдлэлийн маркийг тодорхойлсон лабораторийн дүгнэлт/;

-хайс, парапет хийсэн арга технологи

/фото зураг, төмөр бетоноор хийсэн бол бат бэхийг тодорхойлсон лабораторийн дүгнэлт/;

-дамжих хавтанг угсарч суурилуулсан байдал /фото зураг, далд ажлын акт, эдлэлийн бат бэхийг тодорхойлсон лабораторийн дүгнэлт/;

-замын далан захын тулгууртай нийлэх хэсгийг байгуулсан байдал, нягтруулсан арга технологи;

-гүүрийн дагуу ба хөндлөн налуу, ерөнхий байдал /20 м тутамд хөндлөн огтлолын, гүүрийн тэнхлэгээр дагуу огтлолын гүйцэтгэлийн зургийг гаргаж ерөнхий байдлаар нь фото зураг видео бичлэг авсан байх/;

г/ ус залах далаанд:

-ус залах далангийн хэмжээ зураг төсөлтэй тохирч байгаа эсэхийг шалгах;

-бетон хавтан болон чулуун бэхэлгээний чанар, зургийн дагуу хийгдсэн эсэх;

-зуурмагаар гажнасан эсэх, хавтангуудын өнцгүүдийн арматуруудыг холбож бетоноор дүүргэсэн эсэх;

-угаагдалтаас хамгаалах чулуун шүдийг /рисберм/ хийсэн байдал /далд ажлын акт, фото зураг/ гүн ба өргөн нь зургийн дагуу байгаа эсэх;

-далангийн хажуу налууугийн хэмжээ зураг төслийн дагуу байгаа эсэх;

-ус залах далангийн гүйцэтгэлийн зургийг хавсаргах /дагуу огтлолыг нийтэд нь, хөндлөн огтлолыг 100 м тутам/

д/ модон гүүрт:

-гүүрийн тэнхлэг, репер, тулгууруудын байршлын гадаслагаа, тэд- гэрийг бэхэлсэн байдал /схемийг хавсаргах/;

-гүүрийн материалуудыг бэлтгэсэн байдал. Гүүрийн шон тулгуур, гол нуруу, хөндлөн нуруу, хар шалыг утас татан цавчиж зургийн дагуу бэлтгэсэн байх;

-шон зоосон арга, технологи, зоосон шонгийн журнал /фото зураг хавсаргах/, зургийн төвшинд суулгасныг баталгаажуулсан акт;

-тулгуурын нүх /котлован/ ухаж суурь хийсэн байдал, өндрийн түвшин /далд ажлын акт, өндөржилт дурандсан акт/;

-тулгуур, хөндлөн нуруу, хавчаар угсарсан байдал /фото зураг/

-гол нуруу угсарсан байдал /фото зураг, гол нурууг хөндлөн нуруутай холбож

бэхэлсэн акт/

-хар шал суулгасан байдал /хар шалны дээд өнгөн гадаргууны тэгш байдлыг дагуу ба хөндлөн тэнхлэгт шалгаж тогтоосон акт, фото зураг, далд ажлын акт/;

-цагаан шал /фото зураг/;

-дугуй цохигч, хайсыг угсарсан байдал /чиг шулуун болсныг шалгаж гаргасан акт, фото зураг/;

в/ зам гүүрийн засвар

Зам, гүүр, хиймэл байгууламжууд, тоноглолуудын их засвар, өргөтгөл, урсгал засваруудын ажлыг шалгахдаа барилгын ажлын үед тухайн хийц хэсгүүдэд хийгдсэн ажлыг шалгах аргачлалын дагуу хийнэ.

Битум барьцалдуулагчаар хийсэн хучилттай замын нөхөөсний ажлыг шалгахдаа:

-хучилтын эвдэрсэн хэсгийг геометрийн зөв дүрс, босоо ирмэг гарган ухсан байдал;

-нүхний ирмэгт битумэн түрхлэг хийсэн байдал;

-суурийн хайргыг сольсон байдал;

-хучилтын нөхөөсийг хийж гадаргуутай тэгшилсэн байдал;

-дагтаршуулсан байдал;

-ашигласан материалын чанар.

Нүхэн засварыг хийхээс өмнөх ба хийсний дараах фото зураг авч хавсаргана.

Зам гүүрийн засварын актууд болон ажлын журналд тухайн зам гүүрийн аль хэсэг, пикетэд хэзээ ямар хэмжээний засвар хийснийг тодорхой бичнэ.

4.6. Авто замын захиалагчийн хяналтын инженер нь далдлагдсан ажил бүрт 3% акт бичүүлж, гарын үсэг зурах ба хийгдсэн ажлын чанар, байдал илэрсэн зөрчлийг барилгын ажлын журналд бичиж засах үүрэг даалгавар өгнө.

4.7. Тухайн объектод ажилласан удирдах хүмүүс /зураг зохиогч, хөндлөнгийн хяналт гүйцэтгэгч ажилтнууд г.м/ ажлын журналыг үзэж урьд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгаж, шинээр өгөх үүрэг даалгавраа бичнэ.

4.8. Авто замын улсын байцаагч нь ашиглалтад оруулах барилгын техникийн бүх баримт бичгийг /далд ажлын актууд, гүйцэтгэлийн актууд, зураг төсөв, гүйцэтгэлийн профиль, санхүүжилтийн эцсийн тооцоо, лабораторийн дүгнэлтүүд г.м/

бэлэн болгосныг шалгасны дараа хүлээж авах комисс дуудах зөвшөөрлийг захиалагч гүйцэтгэгч байгууллагад өгнө. Энэ зөвшөөрөл өгөгдөөгүй нөхцөлд хүлээж авах комисс томилохыг хориглоно.

4.9. Авто замын улсын байцаагч нь орон нутгийн засварлах зам гүүрийн талаарх саналаа аймгийн Засаг даргад танилцуулж уг зам гүүрийг хариуцагч байгууллагын инженерийн хамт газар дээр нь төсвийн тодорхойлолт гарган эрх бүхий байгууллагаар төсөв хийлгэнэ.

4.10. Захиалагч, гүйцэтгэгч гэрээ байгуулах шатанд харилцан тохиролцсоны үндсэн дээр ажлын санхүүжилтийн дараах хэлбэрүүдийн аль нэгийг сонгон авч явуулна. Үүнд:

а/ батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэсэн ажлын нэр төрлөөр санхүүжих /энэ аргыг гол төлөв гүйцэтгэгчийг шууд сонгох болон зам гүүрийн засварын үед хэрэглэнэ/;

б/ урьдчилан төсөв гаргалгүйгээр жинхэнэ хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр /энэ аргыг гол төлөв урьдчилан харах боломжгүй ажил бүхий засвар арчлалтад хэрэглэнэ/;

в/ тогтоосон нормативаар санхүүжүүлэх зам, гүүрийн урсгал засвар, арчлалтад хэрэглэнэ/;

г/ ажлын тодорхой үе шатаар санхүүжүүлэх /төндөрээр гүйцэтгэгчийг сонгох болон хэлцлийн үнээр барилгыг барих үед хэрэглэнэ/;

4.11. Гүйцэтгэгчийн гаргаж ирүүлсэн ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан захиалагчийн хяналтын инженер объект дээр очиж тухайн ажлын чанар, тоо хэмжээ зураг төсөвтэй тохирч байгаа эсэхийг үзэхийн хамт далд ажлын актуудыг шалгаж гарын үсэг зурна.

4.12. Төсөвт заагдсан ажлын тоо хэмжээ, үнэ гэрээгээр болон төсөвт тогтоосон үнийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх хяналтыг хяналтын инженер хариуцна.

4.13. Шаардлагатай гэж үзвэл хяналтын инженер лабораторийн буюу хөндлөнгийн хяналтыг тухайн объект дээр зохион байгуулан ажиллуулж болно.

4.14. Хянагдсан ажлын гүйцэтгэлийг хүлээж авсан санхүүч нь математик тооцоог болон гэрээний үнийг шалгаж Засаг даргаар батлуулан санхүүжүүлнэ.



4.15. Хяналтын явцад илэрсэн зөрчил дутагдал, ажлын гүйцэтгэлийн буруу зөрүүг залруулах ажлыг авто замын ажил гүйцэтгэгч хариуцна.

4.16. Чанаргүй хийгдсэн ажлын гүйцэтгэлийг бууруулан санхүүжүүлэх нь илүү санхүүжилтийг суутгах г.м асуудлыг авто замын захиалагчийн хяналтын инженерийн саналыг үндэслэн Засаг дарга шийдвэрлэнэ.

4.17. Ажлын нэр төрлөөр болон гүйцэтгэлээр санхүүжиж байгаа үед хийц эдлэл, бүтээгдэхүүний үнийн калькуляц, материал худалдаж авсан падаануудыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.

4.18. Тогтоогдсон норматив болон ажлын үе шатаар санхүүжиж байгаа нөхцөлд гэрээ байгуулснаас хойш материал, хийц эдлэл, тээвэр, механизмын зардалд өөрчлөлт орж түүнийг холбогдох газрууд албан ёсоор тогтоовол үлдсэн ажлын өртөгт өөрчлөлт оруулан тооцож санхүүжүүлнэ.

4.19. Үер, бороо, байгаль цаг уурын гамшгийн улмаас урьд нь хийсэн ажил эвдрэх, нэмэгдэл ажил гарах тохиолдолд замын улсын байцаагч оролцон аймгийн онцгой комиссын хэмжээнд акт тогтоож Засаг даргын шийдвэрээр санхүүжүүлнэ. Уг актанд гарсан эвдрэл, гэмтлийг харуулсан фото зураг, видео бичлэгийг хавсаргасан байна.

4.20. Магадлашгүй ажлын актыг санхүүжилтийн аль ч нөхцөлд захиалагчийн хяналтын инженер, гүйцэтгэгчтэй хамтран гаргаж баталгаажуулна.

4.21. Нэр төрлөөр болон үе шатаар санхүүжиж байгаа үед төсөвт тусгагдсан магадлашгүй ажлын зардлыг бүрэн ашиглаагүй нөхцөлд үлдэгдэл хөрөнгийг санхүүжүүлэхгүй.

4.22. Тухайн ажлын төсөвт тусгагдсан түр барилгын төсвийг гүйцэтгэгч гаргаж /тухайн төсөвт тусгагдаагүй титулын түр барилгын төсвийг захиалагчийн хяналтын инженертэй урьдчилан тохирч зураг төслийн байгууллагаар хийлгэнэ/ захиалагчаар

хянуулан Засаг даргаар батлуулан санхүүжүүлнэ.

Тав. Санхүүжилтийн мэдээ тайлан гаргах

5.1. Санхүүжилт хариуцсан мэргэжилтэн нь батлагдсан ажлын гүйцэтгэлийн актыг хүлээн авч хянан тухайн объектын бүртгэлд оруулан, хавтаслаж хадгална.

5.2. Санхүүжилтийг хийхдээ зөвхөн аж ахуйн гэрээнд дурдсан гүйцэтгэгчийн харилцах дансанд мөнгийг шилжүүлэх бөгөөд өөр дансанд шилжүүлэхийг хориглоно.

5.3. Төвлөрсөн журмаар хийгдэж байгаа ажил үйлчилгээ /сэлбэг, битум, бусад материал, тээвэр, түрээсийн төлбөр, зураг төсвийн болон лабораторийн шинжилгээ/-ний төлбөрийг захиалагч гүйцэтгэгчийн тооцоо нийлсэн актыг үндэслэн гүйцэтгэгчийн санхүүжилтээс суутган холбогдох газруудад нь шилжүүлэн тооцож болно.

5.4. Сар бүрийн эцэст зам гүүрийн барилгын болон үйлдвэрлэлийн баазын өргөтгөл, засвар арчлалтын ажлын мэдээг объект бүрээр гаргаж гүйцэтгэгч байгууллагыг санхүүжүүлсэн байдал, өгсөн урьдчилгааны мэдээтэй хамт замын байцаагчаар хянуулан Засаг даргаар батлуулна.

5.5. Авто замын захиалагчийн хяналтын инженер нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тооцоог объект болон байгууллага бүрээр 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж санхүүжилтийн мэргэжилтэнтэй тулган шалгаж Засаг даргаар батлуулна.

5.6. Санхүүжилтийн мэргэжилтэн нь тухайн онд хийгдсэн ажлын гүйцэтгэлийн актуудыг барилга, засвараар зааглан объект бүрээр товьёог хийн үдэж архивт хадгалуулна.

5.7. Орон нутгийн чанартай зам гүүрийн засварын болон санхүүжилтийн улирлын мэдээг дараа сарын 10-ны дотор багтаан Авто замын газар, Сангийн яаманд ирүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хянг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487